

АНУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭРХ МЭДЭЛ

Ж.Бор

АНУ ерөнхийлөгчийн засаглалтай орон гэдгийг дэлхий даяараа мэдэх боловч түүний эрх мэдэл хэр зэргийн цар хүрээтэйг сайн мэдэх нь харин ховор биз ээ. Тиймээс энэ талаар монголын уншигчдад товч танилцуулахад илүүдэхгүй биз ээ.

АНУ-ын Үндсэн хуулийн 11 бүлэгт Ерөнхийлөгчийн эрх мэдлийн хэр хэмжээг тогтоон заасан байдаг. Энэ бүлэгт заасны дагуу АНУ-ын Ерөнхийлөгчөд төр, засгийн гурван өндөр албан тушаалын эрх мэдлийг өгсөн байдаг билээ. Тэрээр төр ба засгийн тэргүүн (сайд нарын танхимын тэргүүн), зөвсөгт хүчний ерөнхий захирагчийн эрх мэдлийг гартаа төвлөрүүлэн атгасан байдаг ажээ.

Төрийн тэргүүн

АНУ-ын ерөнхийлөгч юуны өмнө төрийнхөө тэргүүн юм. Тэрбээр энэхүү албан тушаалыг гүйцэтгэж буйгийнхаа төлөө хөдөлмөрөө голлон үнэлүүлнэ. Ерөнхийлөгч жилд 200 мянган долларын цалин авахаас гадна 50 мянган долларын (ашгийн татвараас чөлөөтэй) нэмэлт зардал гаргуулах эрх эдэлнэ. Мөн гүүнчлэн түүний унаа хөсгийн зардалд 100 мянган доллар (ашгийн татвар авдаг) төсөвлөдөг. Ерөнхийлөгчийн албан тушаалаасаа чөлөөлөгдсний дараа улсаас жил бүр 63 мянган долларын тэтгэвэр өгдөг.

Засгийн тэргүүн

АНУ-ын гүйцэтгэх засаглалын тэргүүний нь хувьд Ерөнхийлөгчд гурван сая гаруй албан хаагчтай яам, тусгай газрын нүсэр аппарат захирагдана. Ерөнхийлөгчөөр тэргүүлжжэнэхүү гүйцэтгэх засаглалын хэлбэр нь яам, тусгай газруудыг захиран гүйцэт гүүлэх тогтолцоог бүрдүүл эх бөгөөд е рөнхийлөгчийн шууд удирдлагын дор байдаг цагаан ордны захиргаа, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэг байгууллагуудаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулна. Энэ тогтолцооны хүрээнд хуулийн дагуу Конгресст ажлаа тайлагнадаг 13 яам (нэгдсэн улсын хэмжээний), 50 гаруй бие даасан удирдах газар, зөвлөл, комиссууд ажиллаж байдаг. Гүйцэтгэх засаглалын чухал бүрэлдэхүүн хэсэг болсон гадаад харилцааны ажил ч Үндсэн хуулиас өлгөсөн эрхийн дагуу Ерөнхийлөгчийн гарт

төвлөрдөг. Тухайлбал Үндсэн хуулийн П бүлгийн П зүйлд зааснаар Ерөнхийлөгч сенатчдын хуралдаанд оролцож буй гуравны хоёр сайшаан баталсан тохиолдолд хүчин төгөлдөр болдог олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах эрх эдэлнэ. Тэрчлэн Сенатын зөвшөөрсний дагуу, элчин сайд, бусад бүрэн эрхт төлөөлөгч ба консулыг томилно. Өөрөөр хэлбэл үүгээр Ерөнхийлөгчид улсынхаа тэргүүн дипломат байх эрхийг олгожээ. Мөн түүнчлэн Сенатаар батлагдах шаардлагагүй хамтын ажиллагааны олон улсын гэрээ хэлэлцээрийг Ерөнхийлөгч бие даан байгуулах эрхтэй. Ер нь төрийн гадаад бодлогын онц эрхийг Нэгдсэн улсын засгийн газарт төвлөрүүлдэг нь америкийн төр ёсны нэг гол зарчим юм. Энэ зарчим нь америкийн төр ёсны федерализмын зарчмаас урган гарч байдаг.

Ерөнхийлөгч гадаад бодлогын чиг шугмыг боловсруулан хэрэгжүүлэхдээ Конгресстэй нягт хэлхээ холбоотой хамтран ажилладаг.

Гадаад бодлоготой холбогдол бүхий чухал шийдвэрүүд гол төлөв Ерөнхийлөгч, Конгресс дахь түүний талынхан, гадаад харилцааны байгууллагууд, улс төрийн хүчнүүд, нийгмийн санал бодлын хоорондох зөрчлийг зохицуулан хэлхэж холбон өгөх хүнд бэрх үйл явцын дунд боловсрогдон гардаг.

Зэвсэгт хүчний ерөнхий захирагч

АНУ-ын Үндсэн хуулийн дагуу Ерөнхийлөгч улсынхаа зэвсэгт хүчний ерөнхий захирагч нь юм. Энэ нь америкийн төр ёсны бас нэг гол зарчим буюу ургэний албан тушаалтан батлан хамгаалах салбарыг удирдах, өөрөөр хэлбэл цэргийн албан тушаалтныг захирах зарчмыг илэрхийлж байдаг.

Гаднын улсад дайн зарлах ба цэрэг зэвсгийн том нэгтгэл бүрдүүлэх, усан цэргийн флот байгуулах эрх мэдэл хуулийн дагуу Конгресст хамаарагдана гэж заасан боловч үнэн хэрэг дээрээ их төлөв ерөнхийлөгч тэр эрх мэдлийг эдэлнэ.

Улс орны дотоодод түгшүүртэй байдал бий болсон нөхцөлд Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий захирагчийнхаа эрхийг эдэлдэг. АНУ-ын Үндсэн хуулийн 1У бүлгийн 1У зүйлд зааснаар Нэгдсэн улсын Засгийн газраас бүх штатуудад "өөрөөр өөрийгөө удирдах эрх олгодог" боловч тухайн Штатын гаргасан хүсэлтийн дагуу "дотоодын хүчирхийлээс" түүнийг Засгийн газар хамгаална гэжээ. Үүнийг өнгөц харахад бидний дээр өгүүлсэн федерализмын тухайн зарчмын гол бүрэлдэхүүн хэсэг болсон Нэгдсэн улсын бүрэн эрхт байдал түүний бүх нутаг дэвсгэр дээр адил тэгш тархана. Нэгдсэн улс ба Штатын хуулийн хооронд зөрчил гарсан тохиолдолд зөвхөн Нэгдсэн улсын хууль хүчин төгөлдөр үйлчилнэ гэдэг ёс журам зөрчигдөж байгаа мэт байдаг. Тодруулж хэлбэл Үндсэн хуульд туссан байдлаар бол аль нэг Штатад

дотоодын хүчирхийллийн улмаас иргэдийн эрх зөрчигдөж, тэр зөрчигдсөн эрхийг уг Штатын эрх баригчид сэргээн хамгаалахаас татгалзаж буй тохиолдолд Нэгдсэн улсын Засгийн газар уг хэрэгт оролцож буй хууль ёсыг сэргээн тогтоох эрхгүй мэт болж байна. Гэсэн хэдий ч тийм эрх мэдэл Ерөнхийлөгчдөд зэвсэгт хүчний ерөнхий захирагчийнх нь хувьд бий.

Ерөнхийлөгчийн өөрийнх нь ойлгож буйгаар Нэгдсэн улсын засаг захиргааны эсрэг чиглэсэн ямар нэг байгууллага, нэгдэл холбооны хууль бус ажиллагаанаас, аль эсвэл бослого тэмцлийн" улмаас аль нэг Штатад Нэгдсэн улсын хууль мөрдөгдөх боломжгүй болжээ гэж үзсэн тохиолдолд тус Штатын эрх баригчдын хүсэлт гаргахыг хүлээлгүйгээр Үндэсний гвардийн юм уу, байнгын зэвсэгт хүчний ангиудыг хөдөлгөж журам тогтоох эрхтэй. Үүний зэрэгцээ Нэгдсэн улсын ба Штатын хууль мөрдөгдөн сахигдахад саад учирч байгаагүйгээд Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор олгосон эрхээ аль нэг Штатын хүн амын тодорхой хэсэг алдахад хүрсэн ба "энэ Штатын эрх баригчид тэрхүү эрхий нь хамгаалж өгөх чадваргүй, аль эсвэл хамгаалж өгөхгүй байна" гэж үзвэл өөрийн үзэмжийн дагуу зэвсэгт хүчнийг хөдөлгөж "аливаа бослого тэмцэл, дотоодын хүчирхийлэл, хууль бус байгууллага ба төрийн эсрэг хуйвалдааныг" дарах эрхээр АНУ-ын хууль Ерөнхийлөгчийгөө хангажээ.

Хэдийгээр Америкийн Үндсэн хуулинд Ерөнхийлөгчийг Нэгдсэн улсын Штатуудын хууль сахин мөрдөлтийн баталгаа мөн гэж илэрхий тодорхойлолгүйгээр түүнийг гүйцэтгэх ёстой үүргийг зөвхөн " . . . ухамсартайгаар хуулийг дагаж мөрдөхөд санаа тавина" гэж зааж өгсөн боловч Ерөнхийлөгч улс орныхоо зэвсэгт хүчний ерөнхий захирагч байх эрх эдэлдгийнхээ хувьд үнэн хэрэгтээ тэрхүү баталгаа нь яах аргагүй мөн юм. Энэ бол Үндсэн хуулийн дагуу Ерөнхийлөгчийн эдэлдэг эрх мэдэл юм. Тэгэхээр одоо америкийн Үндсэн хуулинд тодорхой заагаагүй боловч амьдрал дээр Ерөнхийлөгч бодитойгоор эдэлж байдаг буюу хуульчлагдаагүй эрх мэдлийн тухай хэдэн үг хэлье.

Хууль санаачлагч

АНУ-ын Ерөнхийлөгчийн ажил үйлсийн бас нэг чухал хэсэг нь хууль санаачлах ажил юм. Дээр хэлснээр хууль санаачлах эрх мэдлийнх нь талаар АНУ-ын Үндсэн хуульд Ерөнхийлөгчдөдөө тодорхой зааж өгөөгүй боловч дэлхийн II дайны дараагаас хууль санаачлах ажилд түүний гүйцэтгэх үүрэг эрс нэмэгдсэн билээ. Тухайлбал чухам тэр үеэс ерөнхийлөгч Нэгдсэн улсын төсвийн төслийг боловсруулан бэлтгэж конгресст оруулах эрхтэй болжээ. Улсын төсвийн төсөл нь богино хугацааны эрхийн акт учраас түүнийг боловсруулан хэлэлцүүлэх явдлыг хууль санаачилж байгаа үйл ажиллагаа гэж үзэх ёстой. Өдгөө Нэгдсэн улсын төсвийн төслийг америкийн засаг захиргаа, төсөв удирдах газар Ерөнхийлөгчийн удирдлагын дор хийж гүйцэтгэдэг.

Ерөнхийлөгчөөс Конгресст оруулж буй улсын төсвийн тухай илгээлтийг телевизээр орон даяар нэвтрүүлдэг бөгөөд энэ үйл явдал нь Ерөнхийлөгчийн

мэрийн хөтөлбөрийг сонгогчдоос дэмжих, Конгресст дороос шахалт үзүүлэх хэрэгт багагүй үүрэгтэй байдаг билээ. Энэ ажиллагааг Ерөнхийлөгч асан Р.Рейган АНУ-ын 80-аад оны эхээр амжилттай ашиглаж, хожим "рейганомика" гэж нэрлэгдэх болсон, тухайн үедээ бол шинэлэг санаагаар дүүрэн байсан эдийн засгийн хөтөлбөрөө Конгрессоор амархан батлуулж байсан юм.

Намын тэргүүн

Ерөнхийлөгчийн улс төрийн үйл ажиллагааны нэг чухал хэсэг болсон намын тэргүүнийх нь ажил үүргийг АНУ-ын Үндсэн хууль огт хөндөлгүй орхисон байдаг. Гэтэл Америкийн хоёр намт улс төрийн тогтолцоо ба сонгуулийн журамн дагуу өрнөдөг намаас Ерөнхийлөгчөд нэр дэвшүүлэх сонгуулийн өмнөх компанитай холбоотой намын их хурлын ажиллагаагаар

хэрэг дээрээ уг намын шинэ тэргүүн буюу Үндэсний хорооны (ардчилсан аль эсвэл бүгд найрамдах намын) даргын албан тушаалын төлөө өрсөлдөх үйл явц өрнөж байна гэж үзэж болохуйц харагддаг. Энэхүү үйл явцын эхний үе шатанд Ерөнхийлөгчөд нэр дэвшиж байгаа буй хэд хэдэн хүнээс сонгуульд ялах боломжтой нэг хүнийг тодруулан гаргана. Дараагийн шатанд тэр хүнийг хүрээлэгсэд болон түүний сонгуулийн хөтөлбөрийг тойрон нягтарч сонгуулийн өрсөлдөөнд бүх намаараа оролцно.

Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн албан тушаалдаа орсныхоо дараа ч намынхаа дотоод ажлын нилээд хэсгийг хянаж байдаг. Энэ чиглэлээрх түүний үйл ажиллагаа нь мэдээжээр өөрийгөө Ерөнхийлөгчөөр дахин сонгуулах, засгийн эрхийг барьж байх намынхаа эрмэлзлэлийг хангахад голлон чиглэгдэж байдаг. Нөгөө талаас Ерөнхийлөгч өөрөө боловсруулсан хуулийн төслийн Конгрессоор батлуулахын тулд Конгрессын хоёр танхим дахь намын бүлэг, мөн өөртэй нь намын харьяалал нэгтэй Штатын захирагч нарт юуны түрүүнд түшиглэж ажлаа явуулах ёстой нь эндээс ойлгогдоно. Конгресст олонхи болж байгаа намаас дэвшсэн Ерөнхийлөгчөд Конгрессоор хуулийн төсөл батлуулахад хялбар байдаг нь ч мөн эндээс харагдаж байна.

Ерөнхийлөгч ба ардчилал

Ардчилсан алсваа улсад гүйцэтгэх засаглалын дарангуйлал тогтохоос сэргийлсэн Үндсэн хуулийн баталгаа заавал байдаг нь ёс юм. Энэ асуудлыг АНУ-ын Үндсэн хуулинд засаглал хуваах зарчмаар зохицуулж байдаг. Нөгөөтэйгүүр Ерөнхийлөгчөөс дарангуй засаг тогтоох боломжийг хаахын тулд Үндсэн хуулийн баталгаа цорын ганц "хориглон тогтоох" хүчин зүйл болгох нь учир дутмаг гэдэг нь ойлгомжтой. Тийм хүчин зүйлүүдийн тоонд хүчтэй парламент, шүүх засаглал төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгсэл ч нийт хүн ам улс төрийн соёлын өрөнхий төвшин ч, нэн ялангуяа хууль бус үйл ажиллагаанд оролцохоос татгалзах цэргийн албан хаагчдын чадвар зэрэг олон зүйл багтах ёстой